



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/157

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сингапур Улсад зохион байгуулагдах тэшүүрийн шорт трекийн олон улсын тэмцээнд оролцох Улаан-Уул сумын харьяат тамирчин Э.Мөрөнгүя, Б.Төгөлдөр, Цагаан-Үүр сумын харьяат тамирчин Ө.Мөнхцацрал, А.Давгадорж, С.Ганхөвсгөл, Хатгал тосгоны харьяат тамирчин Л.Минжин нарт тус бүрт нь 1,000,000 (Нэг сая) төгрөг, Тусгай олимпын дэлхийн зуны наадам Берлин-2023 тэмцээнд хөнгөн атлетикийн төрөлд оролцох Жаргалант сумын харьяат тамирчин А.Баттөгсөд 1,000,000 (Нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 7,000,000 (Долоон сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН